

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

Дундговь Улсын бүртгэлийн хэлтэс
2022.12.04

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	2022 онд Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 42 арга хэмжээг төлөвлөн 100 хувь хэрэгжүүлэн ажиллалаа. 2022 онд Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, Хүний хөгжлийг дэмжих зорилт дэвшүүлэн аймгийн бодлого зорилттой уялдуулан ажиллалаа.	100
1.2.	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	Хэлтсийн вэб сайтад бүрэн байршуулсан. www.dundgovi.burtgel.gov.mn	100
1.3.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	2022 оны үйл ажиллагааны тайлангууд, үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээний үнэлгээ зөвлөмж сайтад байршуулав. Аудит, санхүүгийн хяналт, шалгалтаар акт аваагүй болно.	100
1.4.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	2022 оны үйл ажиллагааны тайланг хэлтсийн вэб сайтад байршуулсан.	100
1.5.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	Хэлтсийн вэб сайтад бүрэн байршуулсан. www.dundgovi.burtgel.gov.mn	100
1.6.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	Үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр цахим хуудсанд 100% байршуулсан.	100
1.7.	албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг цахим хуудсанд 100% байршуулсан.	100

1.8.	өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Иргэдээс бичгээр нийт 31 хүсэлт, 1 гомдол ирүүлсэн байна. Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 19 хүсэлт ирсэн нь иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн хөрвүүлэлтээс иргэдийн мэдээлэл алдаатай, орхигдсон учраас ургийн овог, эцэг эхийн мэдээлэл, төрөлтийн бүртгэл мэдээллийн санд ороогүй, ургийн овог зөрүүтэй, мөн овог нэрийн үсгийн зөрүүтэй, өөрийн хаягт хүүхдээ бүртгүүлэх, хаяг бүртгүүлэх тухай хүсэлтүүдийг холбогдох нотлох баримтын хамт хүлээн авч Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газарт холбогдох материалыг хүргүүлснээр мэдээллийн санд иргэдийн мэдээллийг нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр залруулан оруулж, хариуг иргэд утсаар болон өөрийн биеэр ирж авсан байна. Өргөдөл гомдлын барагдуулалт 100% 1 гомдол нь шинээр төрсөн хүүхдийг төрсний бүртгэлд бүртгүүлэхэд эхийн зөвшөөрөлгүй эцэг гэх хүнээр хүүхдийг овоглосон тухай байсан бөгөөд Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр бүртгэлийг хүчингүй болгосон байна. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 3 хүсэлт ирсэн бөгөөд холбогдох нотлох баримтыг үндэслэн бүртгэл хийгдсэн. Хяналтын улсын байцаагчтай холбоотой 9 хүсэлт ирсэн нь гэрлэлтийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлгүй, эцэг эхийн мэдээлэл буруу орсон, эцэг эхийн нэр үсэг засвартай, РД давхар олгогдсон, хүйс зөрүүлж РД олгосон, сар өдөр зөрсөн гэх мэт зөрчлүүдийг холбогдох нотлох баримтыг үндэслэн Байцаагчийн дүгнэлт гарган шийдвэрлэсэн байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт хяналтын улсын байцаагчийн дүгнэлт 14 хоног, бусад зөрчлүүдийг 7 хоногтоо багтаан шийдвэрлэж байна. Өргөдөл гомдлын барагдуулалт 100%, хугацаа хоцроож шийдвэрлэсэн өргөдөл хүсэлт байхгүй.	100
1.9.	хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Инфографик мэдээг сар бүрийн 25-ны дотор 11 удаа цахим хуудсанд 100% байршуулсан.	100
1.10	мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.		100
Хэсгийн дундаж хувь:			100
Хоёр.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Цагаан-Дэлгэр, Луус сумын бүртгэгчийн сул орон тооны мэдээ 2 удаа цахим хуудсанд байршуулсан.Мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн түр орон тоог нөхөх зарыг цахим хуудсанд байршуулсан.	100

2.2.	албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	ТАЗ-ийн сонгон шалгаруулах тухай журмыг линкээр вэб сайттай холбов.	100
2.3.	албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм цахим хуудсанд 100% байршуулсан.	100
2.4.	хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Хүний нөөц стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам цахим хуудсанд 100% байршуулсан.	100
2.5.	хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	<p>Албан хаагчдын орон сууц, шагнал урамшуулал, ажил эрхлэлт, чаадавхжуулах сургалтуудыг байгууллагын хүний нөөцийн програмд сан үүсгэж байршуулав.</p> <p>Сайнцагаан сумын улсын бүртгэгч Ш.Чулуунд аймгаас орон сууцны дэмжлэг үзүүлж, урьдчилгаа 10,000,000 сая төгрөгийг шийдвэрлэлээ.</p> <p>“Говийн ирээдүй цогцолбор” сургуулийн Монгол хэл уран зохиолын багш М.Нямаа монгол бичгийн 24 цагийн модуль сургалтыг /Сертификаттай/ зохион байгуулахаар албан хаагчидтай хамтран ажиллах гэрээг байгуулсан бөгөөд төвдөө ажиллаж байгаа 15 албан хаагчдын төвшинг тогтоох шалгалт авч хөтөлбөр боловсруулан анхан, дунд гэсэн 2 шатлалд хуваан хичээллээд дуусч, 15 албан хаагч сертификатаа гардан авлаа. Дунд шатанд 12 албан хаагч, ахисан шатанд 3 албан хаагч үргэлжлүүлэн хичээллэж, мэдлэгээ дээшлүүлэхээр боллоо.</p> <p>Улсын бүртгэлийн байгууллагын 82 жилийн ойгоор ажлын амжилт бүтээлээр бусдыгаа манлайлсан албан хаагчид дараах шагналаар шагнагдлаа.</p> <p>Ардын хувьсгалын 100 жилийн ойн медаль -2 Монголын Залуучуудын холбооны шагналаар 4 Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр 3 Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 1 Сайнцагаан сумын “Хүндэт тэмдэг”-ээр 3</p>	100
2.6.	албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам цахим хуудсанд 100% байршуулсан.	100
Хэсгийн дундаж хувь:			100
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			
3.1.	өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг 4 сарын 1 нд, 2022 оны төсвийг 1 дүгээр сарын 10-нд тус тус Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.	100

3.2.	төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Урсгал санхүүжилтээс цалин хөлсний зардалд 313,873.3 мянга, унаа хоолны зардалд 6,146.2 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 42,297.5 мянга, бичиг хэргийн зардалд 4,335.9 мянга, тээвэр шатахуунд 2,500.2 мянга, шуудан холбоонд 1,928.9 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 3,383.9 мянга, хог хаягдал зайлуулах зардалд 29.9 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 1,250.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, төлбөр хураамжийн зардалд 1,442.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 12,0 мянга, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 200,0 мянган төгрөг, нийт 377,401.6 мянган төгрөг зарцуулж, 72,744.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй төсвийн гүйцэтгэл 83.8% байна.	100
3.3.	санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар 2022 оны 1 дугаар сард аудит хийж санхүүгийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй, “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 4 сарын 29 нд Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.	100
3.4.	хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	УБЕГ-аас тус хэлтсийн 2022 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 80,000.0 мянган төгрөгөөр баталсан. 11-р сарын 30-ны байдлаар орлогын төлөвлөгөөгөөр 73,333.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээс, 62,835.9 мянган төгрөгийн орлого төвлөрч, жилийн орлогын төлөвлөгөөний биелэлт 78.5 хувьтай байна. Үүнээс 57,812.2 мянган төгрөгийг улсын төсөвт 100% төвлөрүүлсэн.	100
3.5.	төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	2022 оны 12 дугаар сарын 01-ны байдлаар НДШ-ийн 11,919.4 мянга, байр ашиглалттай холбоотой байрны түрээсийн зардлын 775.8 мянга нийт 12,695.2 мянган төгрөгийн өртэй ажиллаж байна. Уг өр төлбөр нь 2022 оны төсвийг батлахдаа төсвийн төсөлд тусгасан дүнгээс хасч баталсан. Цалингийн зардлын төсвийг 2021 оны орон тоо дутуу үеийн цалингийн зардлын гүйцэтгэлээр баталсан нь тайлант онд бүтэн орон тоогоор ажиллаж зөрүү үүссэнтэй холбоотой байна. Дээрх өр төлбөрийг 2022 оны 12 сард бүрэн барагдуулахаар Санхүү аж ахуйн хэлтэст холбогдох судалгаа, гэрээ зэргийг хүргүүлэн ажиллаж байна. 2022 оны 1-р улирлын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарын 4 сарын 8-ны дотор Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.	100

3.6.	таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	Сар бүр дараа сарын 8-ны дотор Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.	100
3.7.	цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	Сар бүр дараа сарын 8-ны дотор Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.	100
3.8.	бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Сар бүр дараа сарын 8-ны дотор Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.	100
3.9.	шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Шилэн дансны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд нийт 133 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 133 мэдээллийг хугацаа хоцролгүй үнэн зөв, бүрэн байршуулж 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хугацаанаас нь өмнө 3 сарын 31 нд Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.	100
3.10	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	Сар бүр дараа сарын 8-ны дотор Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан	100

3.11	худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	Сар бүр дараа сарын 8-ны дотор Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.	100
3.12	мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Тендер зарлагддаггүй	-
3.13	төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Сар бүр дараа сарын 8-ны дотор Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан	100
3.14	мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Сар бүр дараа сарын 8-ны дотор Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.	100
3.15	хууль тогтоомжид заасан бусад	<p>УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст тус хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт хуулийн хугацаанд нь хүргүүлж, аудитлагдсан санхүүгийн тайлан ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн. 2022 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайланг УБЕГ-ын СААХ-т Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу улирал бүр, дараа сарын 15-ны дотор хуулийн хугацаандаа хүргэгдэж нэгтгэгдсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2022 оны 2-р сард 2021 оны жилийн эцсийн өмчийн мэдээ, захиргааны статистик маягтыг нөхөж хугацаанд нь хүргүүлэн ажилласан.</p> <p>Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж байна. УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс зэрэг газруудад сар, улирал бүр тайлан, мэдээ үнэт цаас зарцуулалтын тайланг хуулийн хугацаанд хүргүүлж, баталгаажуулан харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн. Үнэт цаас маягтуудыг тухай бүр орлого авч сар бүрийн зарцуулалт, үлдэгдлийн мэдээ тайлан гаргаж, үйлчилгээний төлбөрийг төрийн сангийн дансанд төвлөрүүлэн сар бүр улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна.</p> <p>Сар бүр дараа сарын 8-ны дотор Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан. 11 удаа</p>	100

Хэсгийн дундаж хувь:		100	
Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн			
4.1.	үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Иргэний улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай нээлттэй ил тод үзүүлэх үүднээс авах үйлчилгээтэй холбоотой бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, үйлчилгээний төрөл, үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл зэргийг нэг цэгийн үйлчилгээний мэдээллийн самбар болон вэб сайтад бүрэн байршуулсан. УБЕГазрын вэб сайтны линкийг хэлтсийн цахим хаягтай линкээр холбосон.	100
4.2.	тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	хамааралгүй	-
Хэрэгжилтийн дундаж хувь:		100	

(Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөн баталсан бөгөөдүүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)

НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ, ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ, КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс
сарын 08-ны өдөр

2022 оны 06 дүгээр

№	Хуулийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн	хэрэгжилт	хувь
I. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ						
Зорилт 1. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг нээлттэй болгох						
1	8.6.19.	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг эрчимжүүлэх, бүрэн хамруулах ажил зохион байгуулах	4 дугаар сарын 25	-Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоо мэдээ, бүртгүүлээгүй хуулийн этгээдийн судалгааг 2 хэлбэрээр гаргаж, бүртгэлд бүрэн хамруулах ажлыг бүртгэлийн бүх нэгжээр дамжуулан хэрэгжүүлсэн байна.	УБЕГ-аас ирүүлсэн 2022 оны 04 сарын 26-ны өдрийн №1/3681 тоот чиглэлийн дагуу УИХ-аас 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр баталсан Татварын ерөнхий хууль/ шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулсан хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгэх ажлын хүрээнд нийт 318, бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн мэдээлэл ирснээс 54 хуулийн этгээд нөхөн бүртгэлд хамрагдаж үүнээс холбогдож чадаагүй 92, холбогдсон 66, хувьцаа эзэмшигч нас барсан 9, татан буугдсан 9, Хувьцаа эзэмшигч өөр газар байгаа 44, цаашдаа үйл ажиллагаа явуулахгүй 41, хориг тавьсан 3 зэрэг шалтгаануудтай байна.	100
II. ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ						
Зорилт 1. Хуульд заасан үндэслэлээр мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах						
19	10.2-10.5	Ирц бүртгэлийн системд ажилтныг таньж, баталгаажуулах үйлдлийг	4 сарын 15	-Ирц бүртгэлийн системд ажилтныг таньж,	2022 оны 05 сарын 02-ны өдрөөс тус хэлтсийн хурууны хээгээр таних цаг бүртгэлийн	100

		биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ээс бусад биометрик мэдээллээр ашиглах ажлыг зохион байгуулах, ажилтнаас бичгээр зөвшөөрөл авах, ашиглах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах		баталгаажуулах үйлдэлд биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ээс бусад биометрик мэдээллээр ашигласан байна. -Ажилтнаас бичгээр зөвшөөрөл авсан байна. -Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байна.	төхөөрөмжийг ашиглалтнаас гаргаж ERP систем ашиглан цахимаар цаг бүртгэлээ хийх тохиргоог хийж нэвтрүүлээ.	
Зорилт 2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх						
23	27	Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжийг ажлын байранд хүний болон мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор байршуулах, мэдээлэлд хандах эрхгүй этгээд хандахаас урьдчилан сэргийлэх техникийн болон үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх	5 дугаар сарын 1	-Зөвшөөрөгдсөн байршилд байрлуулсан байна. -Анхааруулгыг иргэнд саадгүй харах боломжтойгоор байршуулсан байна.	Ажлын байрны архив үйлчилгээний танхим, оффист 3 камер байршуулсан ба хэлтсийн Хяналтын улсын байцаагчийн өрөөнд дэлгэц, үндсэн холболтыг хийсэн. Зөвхөн дүрсний камержуулалт хийгдсэн болно.	100
			Байнга	Дүрсний бичлэгт мэдээллийн эзнээс бусад хүний мэдээлэл байгаа тохиолдолд дүрсний бичлэгийг үзүүлэх, хуулбарлаж өгөхгүй байх.		
IV. Сургалт, сурталчилгаа						
28	-	Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль тогтоомж, нээлттэй өгөгдлийн талаар сурталчлах, албан хаагчдын харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ,	Жилдээ	-3-с доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна. -Албан хаагчдын мэдлэг дээшилсэн байна.	Хэлтсийн цахим мэдээллийн сан, нэгдсэн сүлжээ, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллах талаар албан хаагчдад 5 удаагийн мэдлэг олгох сургалтыг онлайнаар зохион байгуулсан. Аймгийн	100

		сургалт зохион байгуулах			
29	-	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар сурталчлах, сургалт зохион байгуулах		-Мэдээллийн технологийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр /төлөвлөгөө/ батлан хэрэгжүүлсэн байна. -Цахим хөгжлийн багц хуулийг хэрэгжүүлэх хүрээнд сурталчилгааны ажлууд хийгдсэн байна.	ЗДТГ-аас зохион байгуулсан 2 удаагийн сургалтанд албан хаагчид хамрагдаж хууль эрх зүйн талаар болон ERP програмын талаар мэдээлэл авлаа.
30	-	Мэдээллийн технологийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр /төлөвлөгөө/ батлан хэрэгжүүлэх			